

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР
ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2023 оны 06 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны Салбар зөвлөл нь Төрийн албаны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан журам, зааврын хэрэгжилтийг системийн хэмжээнд хангах, түүнд хяналт тавих, төрийн алба хаагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалахад үндсэн үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

Нэг. Ерөнхий хэсэг.

1.1. Салбар зөвлөлийн үндсэн үйл ажиллагаа, төлөвлөгөө, зохион байгуулалтын ажил, үр дүн

Тус зөвлөл нь ШШГБ-ын хэмжээнд 2023 оныг “Байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах, аюулгүй байдал, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, алба хаагчийн хөгжлийг дэмжих” жил болгох зорилт, Төрийн албаны тухай хууль, холбогдох журам, заавар болон Төрийн албаны зөвлөлийн бодлого, шийдвэрт нийцүүлэн Салбар зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны 4 үндсэн арга хэмжээний хүрээнд 24 ажил, үйлчилгээ бүхий гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр батлан ажиллаж байна.

Төрийн албаны зөвлөлийн бодлого, шийдвэр, тогтоол, журам, заавар, байгууллагын Салбар зөвлөлийн үйл ажиллагаа, хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудал, хүний нөөцтэй холбоотой асуудлаар алба хаагчдад мэдээлэл хийж, ажлын байрны сул орон тооны зарыг байгууллагын вэб сайтад байршуулсан.

Салбар зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайлан, мэдээ судалгааг гарган, 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн ШШГЕГ-ын даргын 01/69 дүгээр албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, үйл ажиллагааны тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг ШШГЕГ-ын веб хуудаст байрлуулан, бие бүрэлдэхүүн болон үйлчлүүлэгч-иргэдэд мэдээлэн сурталчилсан нь ил тод, нээлттэй байдлыг хангах нэг гол арга хэмжээ боллоо.

Байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцсэн хүний нөөцийг бэлтгэх, бэлтгэгдсэн хүний нөөцийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх давтан болон мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, мөн алба хаагчдын боловсролын түвшинг нэмэгдүүлэх зорилгоор гадаадын болон дотоодын их, дээд сургууль, удирдлагын академид элсэн суралцуулах зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд 2023 оны эхний хагас жилд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Сургалтын талаар:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/215 дугаар тушаалаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад 2022-2023 онд зохион байгуулах сургалтын хөтөлбөр”-ийг батлуулан,

нийт анги, байгууллагуудад хүргүүлж, сар бүр сургалтын тайлан мэдээг авч нэгтгэн, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж байна.

Харьяа анги байгууллага, салбар нэгжүүд сургалтын хөтөлбөрийн дагуу өөрсдийн анги нэгжийн алба хаагчдын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн сургалтын төлөвлөгөө боловсруулж, нэгжийн даргын тушаалаар батлуулан, сургалтыг дараах чиглэлийн хүрээнд зохион байгуулан ажиллаж байна. Үүнд:

- Алба хаагчийн бие бялдрын бэлтгэлжилт, норматив хангах сургалт;
- Цэргийн албаны нийтлэг дүрэм, цэргийн хэргийн мэдлэг олгох сургалт;
- Үндэсний Монгол бичгийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт;
- Гадаад хэл мэдлэгийн түлхүүр сургалт;
- “Зангиа академи”-ийн цахим сургалт;

2023 оны эхний хагас жилийн байдлаар удирдах ажилтнууд, хорих анги, байгууллагын харуул хамгаалалт, гүйцэтгэх ажил эрхэлсэн дэд дарга, цагдан хорих байрны дарга, төлөөлөгч, ахлах төлөөлөгч, ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч, архив, бичиг хэргийн ажилтан, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ажилтнууд, хүний тоо бүртгэлийн байцаагч, туслах, холбоо мэдээллийн технологийн инженерүүд, эмч, эмнэлгийн ажилтнууд зэрэг 10 төрөл мэргэжлийн 696 алба хаагч танхимын болон цахим сургалтад хамрагдсан.

- Хөмрөг үүсгэгч байгууллагуудын архив, бичиг хэргийн ажилтан болон бичиг хэргийн ажил хариуцсан алба хаагчдад Архивын ерөнхий газрын Мэргэжил, арга зүйн удирдлагын газрын архивын баримтын тоо бүртгэл, статистик мэдээ хариуцсан мэргэжилтэн Л.Өнөртуяа сургалт зохион байгуулсан.

Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвтэй хамтран “Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх” сургалтад хотын бүсийн хорих анги, байгууллагуудын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ажилтнууд болон аюулгүй байдал хариуцсан алба хаагчид хамрагдсан.

ШШГЕГ-ын алба хаагчдад Удирдлагын академийн багш нараар Манлайлал, Хүний эрх ба жендэр, Албан бичиг боловсруулалт сэдвүүдээр нийт 15 цагийн сургалт зохион байгуулсан.

Мөн Чингэлтэй дүүргийн онцгой байдлын хэлтэс, Гал унтраах 10 дугаар ангитай хамтран Гал унтраах, гамшгаас урьдчилан сэргийлэх тухай 2 цагийн танхимын сургалт зохион байгуулсан.

1.2. Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэрийн хэрэгжилт, хуралдааны тэмдэглэлийг албажуулсан байдал:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөл нь батлагдсан “Хуралдааны дэг”, “Ажил үүргийн хуваарь”-ийг мөрдөж байгаа бөгөөд байгууллагын цахим хуудсанд байршуулан иргэд, үйлчлүүлэгчдэд мэдээлэн сурталчилж ажиллаж байна.

Салбар зөвлөл нь хууль, журамд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 7 удаа хуралдан шаардлагатай цаг үеийн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэн ажилласан.

Хуралдааны хөтөлбөрийг урьдчилан гаргаж батлуулан, хуралдааны тэмдэглэлийг албажуулан, холбогдох материалуудыг нэгж болгон цэгцлэн ажиллаж ирсэн.

Салбар зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайлан, мэдээ судалгааг гарган, 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн ШШГЕГ-ын даргын 01/69 дүгээр албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, үйл ажиллагааны тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг ШШГЕГ-ын веб хуудаст байршуулсан.

Салбар зөвлөлийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2023.01.31-ний өдрийн 01/249 дүгээр албан бичгээр тус газрын дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулах саналыг хүргүүлсэн.

Энэхүү саналтай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2023.02.14-ний өдрийн 43 дугаар тогтоолоор өөр албан тушаалд томилогдсон нэр бүхий 3 алба хаагчийг салбар зөвлөлийн гишүүнээс чөлөөлүүлж, шинээр холбогдох алба хаагчдыг томилуулсан.

Тайлангийн хугацаанд Салбар зөвлөлд ирүүлсэн өргөдөл гомдол байхгүй.

Төрийн албаны тухай хуульд нийцүүлэн Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор батлагдсан журам, зааврыг алба хаагчдад мэдээлэн сурталчилж судлуулах, хүний нөөцийн холбогдолтой асуудлыг шийдвэрлүүлэхээр ШШГЕГ-т уламжлахдаа анхаарах зарим асуудал зэргээр тодорхой үүрэг чиглэлийг анги, нэгжийн удирдлага, хүний нөөц, хэвлэл мэдээлэл, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн нарт өгч, биелэлтийг хангуулж ажилласан.

Хоёр: Үндсэн хэсэг:

2.1. Хууль, журам, заавар, төрийн албаны стандартын хэрэгжилтэд хяналт шалгалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байдал, үр дүн

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа анги, нэгжийн үйл ажиллагаанд төрийн хууль тогтоомжийн хэрэгжилт, алба хаагчдын сахилга, хариуцлага, байгууллагын болон төрийн алба хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлт, биелэлт, хүний нөөцийн бодлогын бичиг баримт, хувийн хэргийн бүрдүүлэлт, цахим системийн хөтлөлт зэрэг бүх л талын ажлыг хянан шалгах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хуваарийг батлан мөрдүүлж ажилласан.

ШШГБ-ын 2022 оны үйл ажиллагааны үнэлгээний мөрөөр дүгнэлт, зөвлөмж боловсруулж харьяа алба, газар, хэлтэст 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 01/260-01/264 дүгээр албан бичгээр тус тус хүргүүлсэн.

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд 4 зорилтын 15 арга хэмжээг хэрэгжүүлж, өмнөх онд 68.67 хувь үнэлэгдсэнээс өссөн дүнгээр 71.33 хувьтай үнэлэгдлээ.

Тайланг 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 01/1243 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

ШШГБ-ын 2022 оны үйл ажиллагааны үнэлгээний мөрөөр дүгнэлт, зөвлөмж боловсруулж харьяа алба, газар, хэлтэст 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 01/260-01/264 дүгээр албан бичгээр тус тус хүргүүлсэн.

“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хүрээнд 5 зорилтын 9 арга хэмжээг хэрэгжүүлж, өмнөх оноос өссөн дүнгээр 65.56 хувьтай үнэлэгдсэн. 2022 оны эхний хагас жилийн байдлаар 53.3 хувийн хэрэгжилтэй байснаас 12.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Тайланг 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 01/1243 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээ. Мөн www.unelgee.gov.mn цахим санд тайлагнасан болно.

Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хүрээнд ШШГБ-ын 100 сая мод тарих хөтөлбөр, цахим шилжилтийн талаарх ажлын 2022 оны хэрэгжилтийг гарган ХЗДХЯ-нд 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр цахим хэлбэрээр хүргүүлсэн.

Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд 2 зорилтын 2 арга хэмжээг хэрэгжүүлж, 63.33 хувтай тус тус үнэлэгдлээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хүрээнд 25 шийдвэрийн 29 арга хэмжээг хяналтад авч хэрэгжилтийг зохион байгуулж ажиллаж байна.

Дархан-Уул аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-445 дугаар нээлттэй хорих ангид 2023 оны 05 дугаар сарын 03-06-ны өдрүүдэд төлөвлөгөөт хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийгдсэн.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр зөвлөмж боловсруулж Хяналт шалгалт, аюулгүй байдлын газрын 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 07/1114 дүгээр албан бичгээр тус ангид хүргүүлсэн. Зөвлөмжийн гүйцэтгэлийг 2023 оны 09 дүгээр сард шалгах болно.

2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийгдсэн судалгааг нэгтгэж төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж бүрээр нэгтгэлийг гаргаж, дүн шинжилгээ хийж 2023 оны 04 дүгээр сард ХЗДХЯ-нд цахимаар хүргүүлсэн.

Мөн аудитаар илэрсэн зөрчлийн талаар нэгдсэн мэдээллийн сан үүсгэн ажилласан.

Цаашид 2023 оны 3 дугаар улирлын байдлаар зөвлөмжийн хэрэгжилтийн дагуу хийгдсэн ажлыг харьяа анги, байгууллагуудаас хүлээн авч нэгтгэн дүгнэлт хийхээр төлөвлөж байна.

“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллах зорилгоор 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 07/362, 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 07/928, 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 07/1223 дугаар албан бичгээр нийт хорих анги, байгууллагуудад үүрэг хүргүүлж ажилласан.

2.2. Төрийн жинхэнэ албанд ажиллах хүний нөөцийг сургаж бэлтгэх, нөөц бүрдүүлэх, томилогдох ажилтны сонгон шалгаруулалт,

нэр дэвшүүлсэн ажиллагаа ил тод, нээлттэй байдлыг хангасан байдал, үр дүн

ДХИС-ийн Ахлагчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн “Харуул хамгаалалтын албаны ажилтан” бэлтгэх чадамжид суурилсан 90 хоногийн сургалтад 165 иргэнийг танхимын хэлбэрээр суралцуулан төгсгөсөн.

Мөн Шийдвэр гүйцэтгэгчийн нөөц бүрдүүлэх зорилгоор “Шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт”-ыг 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдөр явуулж, сорилын болон ярилцлагын шалгалтад тэнцсэн 33 оролцогчийг Орон тооны бус мэргэжлийн комиссоос шалгалтын дүнг баталгаажуулж, шийдвэр гүйцэтгэгчийн нөөцөд бүртгэсэн.

Байгууллагын сул орон тоог нөхөх зорилгоор ОХУ-ын ДХЯ-ны харьяа их, дээд сургууль, ДХИС-ийн ШШГА-ны сургууль, Ахлагчийн сургууль төгсөгчид болон шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэд, ажиллаж байгаа алба хаагчдаас нөөц бүрдүүлэлтийг зохион байгуулан ажиллаж байна.

2023 оны эхний хагас жилийн байдлаар ШШГЕГ-ын даргын тушаалаар 274 иргэнийг шинээр, 178 алба хаагчийг албан тушаалд дэвшүүлэн, 204 алба хаагчийг шилжүүлэн томилсон.

Нэгжийн даргын тушаалаар 95 алба хаагчийг шилжүүлж, 137 иргэнийг шинээр томилсон байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн сул орон тоог нөхөх, нөөц бүрдүүлэх зорилгоор сонгон шалгаруулалтын зарыг мэдээлж, ажилд орох хүсэлт гаргасан иргэдийг бүртгэж, журамд заасан болзол шаардлага, тухайн албан тушаалд тавигдах ерөнхий ба тусгай шаардлагад нийцүүлэн сонгон шалгаруулалтыг явуулж, ДХИС-ийн Ахлагчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн “Харуул хамгаалалтын албаны ажилтан” бэлтгэх сургалт, “Офицер” бэлтгэх дамжаанд хамруулж, тэнцсэн иргэдийг албан тушаалд томилон ажиллаж байна.

2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Сувилахуйн сургуулиас зохион байгуулсан “Ажил олгогчидтой хийх нэгдсэн уулзалт”-д 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг оролцож, Сувилахуйн сургуулийн төгсөх дамжааны оюутнуудтай уулзан тус байгууллагад ажиллахын давуу талыг сурталчилсан.

Нэн шаардлагатай албан тушаалын сул орон тооны мэдээллийг болон ажилд орох хүсэлтэй иргэдэд тавигдах шаардлага, бүрдүүлэх материалын жагсаалт зэргийг байгууллагын цахим хаягт тогтмол байршуулж байна.

Ерөнхий боловсролын төгсөх ангийн хүүхдүүдэд эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Бидний бахархал” арга хэмжээг Хан-Уул дүүргийн 32, 75 дугаар дунд сургуулиудад зохион байгуулсан.

Байгууллагын сул орон тоог нөхөх зорилгоор өмнөх оны нөөцөд бүртгэлтэй ДХИС-ийн ШШГА-ны сургуулийн 3 сонсогч, Ахлагчийн сургуулийг төгссөн 75, шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн 45 иргэнээс нөөц бүрдүүлэлтийг зохион байгуулан ажиллаж байна.

Алба хаагчдын шилжилт хөдөлгөөний талаар:

2023 оны эхний хагас жилд хийгдсэн алба хаагчдын шилжилт хөдөлгөөнийг 2022 оны мөн үетэй харьцуулахад ШШГБ-д шинээр томилогдсон алба хаагчийн тоо 96.6, дэвшин томилогдсон алба хаагчийн тоо 15.5 хувиар, шилжсэн алба хаагчийн тоо 4.1 хувиар, албан тушаал буурсан алба хаагчийн тоо 1.7 дахин, тэтгэвэрт гарсан алба хаагчийн тоо 70.2 хувиар, ажлаас чөлөөлөгдсөн алба хаагчийн тоо 85.5 хувиар, халагдсан алба хаагчдын тоо 2.6 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Шилжилт хөдөлгөөн



“Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ыг мөрдөн ажиллаж удирдлагаас гаргасан тушаал, шийдвэр болон алба хаагчийн, чөлөөлөгдсөн, тэтгэвэрт гарсан, шилжүүлэн томилсон нийт 13435 хуудас материалыг хувийн хэрэгт баяжилт хийж, шинээр албан тушаалд томилогдсон 129 алба хаагчийн хувийн хэргийг нээн товъёог хөтөлж, харьяа газар, анги, салбар нэгжид байршуулсан.

Төрийн албаны зөвлөлийн “7:4:10” арга зүйн сургалтад харьяа алба, хорих анги, газар, салбар нэгжийн алба хаагчдыг тогтмол хамруулах талаар анхааран ажилласан ба нийт 16 удаагийн сургалтад хамруулсан.

Алба хаагчдын шагнал урамшууллын талаар:

2023 оны эхний хагас жилийн байдлаар Төрийн дээд шагналаар 128, Хууль зүй, дотоод хэргийн яамны шагналаар 112, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шагналаар 227, мөнгөн шагнал урамшууллаар 165, анги, нэгжийн шагнал урамшууллаар 444 алба хаагчийг шагнасан бол бусад байгууллагын шагналаар 72, нийт 1148 алба хаагчийг тус тус шагнаж урамшуулсан байна.

Алба хаагчдын гаргасан сахилгын зөрчлийн талаар:

2023 оны эхний хагас жилийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хандаж, сахилгын зөрчил гаргасан 89, Хорих анги, Шийдвэр гүйцэтгэх алба, салбар нэгжийн даргын тушаалаар 309, нийт 398 алба хаагчдад сахилгын шийтгэл ногдуулсан нь нийт алба хаагчдын 12.4 хувийг эзэлж байна.

Оногдуулсан сахилгын шийтгэлийн төрлөөр:

Оногдуулсан сахилгын шийтгэлийн төрөл	ШШГЕГ-ын даргын тушаалаар		Харьцуул алт	Нэгжийн даргын тушаалаар		Харьцуул алт
	2022 оны хагас жил	2023 оны хагас жил		2022 оны хагас жил	2023 оны хагас жил	
Сануулах	-	35	-	72	122	+69.4%
Албан тушаалын цалингийн хэмжээг бууруулах	-	18	-	73	100	+36.9%
Цолны мөнгийг 3 сар хүртэл хугацаагаар хасах	-	4	-	55	72	+30.9%
Цэргийн цолыг бууруулах	6	4	-33.3%	-	7	-
Албан тушаал бууруулан томилох	1	18	+1.7 дахин	-	-	-
Халах	5	10	+1 дахин	-	8	-
НИЙТ ДҮН	12	89	+6.4 дахин	200	309	+54.5%

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд 2023 оныг “Байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах, аюулгүй байдал, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, алба хаагчийн хөгжлийг дэмжих” жил болгон зарласан. Тус зорилтын хүрээнд:

- 1.Цахимжуулах ажлыг эрчимжүүлж, төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх боломжийг нэмэгдүүлэх;
2. Байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх менежментийг бэхжүүлэх;
- 3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх зүйн орчинг сайжруулж, алба хаагчийн эрх зүй, нийгэм, эдийн засгийн баталгааг хангах;
- 4.Хүний нөөцийн удирдлагыг оновчтой зохион байгуулж, тогтвор суурьшилтай ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх;
- 5.Алба хаагчийн хэрэгцээ шаардлагад суурилсан сургалтын арга хэлбэрийг нэвтрүүлж, мэргэшсэн чадварлаг хамт олныг төлөвшүүлэх;

2023 оны эхний хагас жилийн байдлаар дээрх зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Цахимжуулах ажлыг эрчимжүүлж, төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх боломжийг нэмэгдүүлэх;

Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн, чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж, хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан, үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль, тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт, албан тушаалтны овог, нэр, харилцах утасны дугаар, цахим шуудагийн хаяг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, статистик мэдээ, зохион байгуулах

олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр, ажлын байрны сул орон тооны мэдээлэл, албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам, ёс зүйн дүрэм, хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам, үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалт болон үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, үйл явдлын мэдээ мэдээллийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын www.cd.gov.mn цахим хуудаст холбогдох линкийг байршуулан, иргэд, олон нийтийн мэдээ, мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлсэн.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд 68 төрлийн мэдээллийг ил тод, нээлттэй болгохоор заасан ба мэдээллийг ил тод болгосон эсэхийг тодорхойлох 98 шалгуур үзүүлэлтийн дагуу холбогдох мэдээллүүдийг cd.gov.mn цахим хуудаст байршуулж, хэрэгжилтийг Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн бөгөөд тус яамны <https://shilen.gov.mn/> сайтад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар **98.70** хувиар үнэлэгдэж, агентлагуудаас долдугаар байрт жагсаж байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд харьяа анги, байгууллага, салбар нэгжүүдэд нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажиллах тухай үүрэг чиглэлийг 05/1266 дугаар албан бичгээр 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Мөн мэдээ мэдээллийн агуулга, хүртээмж, ач холбогдлыг сайжруулах, гарч болохуйц сөрөг үр дагавараас урьдчилан сэргийлэх зорилгоор харьяа анги, байгууллага, салбар нэгжийн хэмжээнд бэлтгэн түгээж буй мэдээ мэдээлэл, контент, нэвтрүүлэг, постер, шторк зэргийг урьдчилан хянаж, редакторлан, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч нийтлэх зөвшөөрөл өгч хэвшүүлсэн.

Тайлант хугацаанд харьяа анги, байгууллага, салбар, нэгжийн хүрээнд зохион байгуулагдсан арга хэмжээ, үйл явдлын нийт **84** мэдээг хянаж, редакторлан нийтлэх зөвшөөрөл олгож ажиллалаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын www.cd.gov.mn сайтад **76**, фэйсбүүк хуудаст **210**, дотоод мэдээллийн самбарт **68** мэдээ мэдээллийг тус тус боловсруулан байршууллаа. Цахим хуудаст давхардсан тоогоор **162921** удаагийн хандалт хийгдсэн байна.

Байгууллагын албан ёсны cd.gov.mn сайтад шаардлагатай цэсийг нэмж баяжилт хийх хүрээнд “Төрийн мэдээлэл” цэсэнд эмхэтгэлийн 21 дүгээр, “Албадан дуудлага худалдаа” цэсэнд **20** зарыг тус тус байршуулсан.

Мөн Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 96 дугаар тогтоолын хавсралт “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-т заасны дагуу байгууллагын цахим хуудаст оруулж байгаа мэдээг монгол бичгээр хөрвүүлэн байршуулж байна.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага” фэйсбүүк хуудасны дагагч 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар **44411** байгаа бөгөөд тус тоон үзүүлэлтийг өмнөх оны жилийн эцсийн байдалтай харьцуулахад **3803** дагагчаар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Мөн байгууллагын фэйсбүүк хуудасны онлайн чатаар хандсан **916** иргэнд хорих ял эдлүүлэх үйл ажиллагаа, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, хорихоос

өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа, сургалтын чиглэлээр асуусан асуултад мэдээлэл өгөх албан тушаалтныг холбон тухай бүрт нь хариу өгч ажилласан.

Байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх менежментийг бэхжүүлэх

Байгууллагын аюулгүй байдлыг хангаж аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 04:00-05:00 цагийн хугацаанд Төв байр болон Хорих ял эдлүүлэх байрны гэрэлтүүлэг, өрөөний лац, телекамер, галын хор, цонх, автомашины гараж, томилгоот алба хаагчийн үүрэг гүйцэтгэлтийг шалгаж, эрсдэлийн үнэлгээ хийж бага эрсдэлтэй гэсэн дүгнэлт гарсан. Дээрх эрсдэлийн үнэлгээнд хариу арга хэмжээг авч ажиллах талаар зохион байгуулалтын дараах арга хэмжээг авч ажилласан. Үүнд:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хяналт шалгалт, аюулгүй байдлын газрын даргын удирдамж, хуваарийн дагуу Аюулгүй байдал, тусгай ажиллагааны хэлтсийн дарга, хурандаа Ж.Цэрэн-Отгон, ахлах мэргэжилтэн, хошууч Ш.Нямсүрэн, СҮХОГ-ын ҮБТХ-ын ГХАБЭА-ын мэргэжилтэн, хошууч Х.Эрдэнэсайхан, аюулгүй байдал хариуцсан ахлах байцаагч, ахмад П.Алтанхуяг нарын нийт 4 алба хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр 2023 оны 4 дүгээр сарын 26, 27, 28-ны өдрүүдэд Гамшигийн үед ажиллах төлөвлөгөө, тог цахилгааны хэвийн үйл ажиллагаа, барилга, байгууламж, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, галын аюулгүй байдлын чиглэлээр тус тус шалгах хуудас, тухайн орон газар, байршил дээрх биечилсэн үзлэг, шалгалтыг хийж хариуцсан алба хаагчдад илэрсэн зөрчил, дутагдлын талаар тайлбарлаж, зөрчлийг арилгах чиглэлээр зааварчилгаа өгсөн ба үзлэг шалгалтад Улаанбаатар хотын хүрээний алба, анги, шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн нийт 19 салбар / Шийдвэр гүйцэтгэх алба, Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газар, Банкны төлбөр барагдуулах газар, Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги, 407, 409, 421, 441 дүгээр нээлттэй хорих анги, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Газар ивээл-ТӨААТҮГ, Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага, Төр хурх-АНСС-УТҮГ, Баривчлах төв, Хэрэмт цамхаг-УТҮГ, Үйлдвэр, аж ахуйн барилгын хэлтэс, Сүлд спорт хороо, Баривчлах байр, Налайх, Багахангай дүүрэг дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс/ хамрагдсан илэрсэн зөрчлийг талаар ШШГЕГ-ын даргад илтгэх хуудсаар танилцуулж, арилгах тухай хугацаатай үүргийг хүргүүлж ажилласан.

Мөн Баян-өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын барилга, байгууламж, алба хаагчийн аюулгүй байдлыг хангаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийлгэж, тус газрын барилгын дээврийн таазны нуруу мод хуучирсан, хана таазанд цууралт өгсөний улмаас нуралт үүсэх эрсдэлтэй, барилгын цахилгааны утаснууд хуучирч, муудсан цахилгааны холболт стандартын шаардлага хангахгүй гэж гарсан ба Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 10.000.000 төгрөг шийдвэрлүүлсэн байна. 421 дүгээр нээлттэй хорих анги, Дархан-Уул аймаг дахь ШШГГ-445 дугаар нээлттэй хорих анги, ШТН ТӨААТҮГ, Өвөрхангай аймаг дахь ШШГГ, Өмнөговь аймаг дахь ШШГГ, Завхан аймаг дахь ШШГГ, Сүхбаатар аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрууд тус тус эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх зүйн орчинг сайжруулж, алба хаагчийн эрх зүй, нийгэм, эдийн засгийн баталгааг хангах;

Хууль зүй, дотоод хэргийн сайдын: 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/172 дугаар тушаалаар Эрүүгийн болон Зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгохтой холбогдуулан хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ШШГЕГ-ын тэргүүн дэд

дарга, бригадын генерал Д.Дамдинцэрэн, дэд дарга, хурандаа Х.Ариунболд, хэлтсийн дарга, дэд хурандаа Э.Бадамсамбуу нар орж ажилласан бөгөөд эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох суурь болон хавсралт судалгааны ажлын хүрээнд хуулийн төслийг боловсруулж, хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төслийн үзэл баримтлал, үр нөлөөний үнэлгээ, урьдчилсан тандан судалгаа зэргийг хийж гүйцэтгэсэн бөгөөд хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэхээр ажиллаж байна.

Шинээр боловсруулж байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тухай хуулийн төсөлд байгууллагын эрх зүйн орчинг сайжруулах, алба хаагчийн эрх зүй, нийгэм, эдийн засгийн баталгааг хангах заалтуудыг бүрэн дүүрэн тусгаж оруулсан.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын өгсөн үүргийн дагуу таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан этгээдэд хяналтын тоног төхөөрөмж буюу цахим бугуйвч ашиглан хяналт тавихад холбогдох хууль, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах санал, хяналт тавих ажиллагааны зардал төсөв, бүтэц орон тоо, хүний нөөцийн талаарх танилцуулга боловсруулах зорилгоор Дотоод хэргийн их сургуулийн Сургалт эрдэм шинжилгээний газрын Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвтэй хамтран ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Эрүү болон Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хуулийн төсөл болон хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн актуудад харьяа 30 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсээс хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээний хэрэгжилтийг боловсронгуй болгох талаарх эрх зүйн зохицуулалтын саналыг 2023 оны эхний хагас жилийн байдлаар авч нэгтгэн Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтэст хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Хүний нөөцийн удирдлагыг оновчтой зохион байгуулж, тогтвор суурьшилтай ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын Ахлагч бүрэлдэхүүний томилгоо, шилжилт хөдөлгөөнийг зохицуулах журмын хэрэгжилтийн хүрээнд нэгжийн хүний нөөц хариуцсан ажилтнуудыг тогтмол мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан эх оронч үзэл төлөвшүүлэх зорилго бүхий “Бидний бахархал” төслийг Чингэлтэй дүүргийн 149, 72, 37, 49, 117, 5, 50, 23, 24, 17, 39, 57, 61 дүгээр ерөнхий боловсролын сургуулиудад зохион байгууллаа. Үйл ажиллагааны үеэр Монгол Улсын гавьяат багш, доктор, профессор, бэлтгэл хурандаа Б.Галиндэв, Үндэсний батлан хамгаалах их сургуулийн Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэнгийн цэргийн түүхийн төвийн дарга, доктор, хошууч Т.Сүхбаатар нар эх оронч үзэл, тусгаар тогтнол, эрх чөлөөний талаар лекц уншиж, сурагчдад мэдээлэл өгснөөс гадна сонирхсон асуултад нь хариулсан. Мөн “Монгол цэргийн музей”, “Мөнхөд дурсагдах баатрууд” ТББ-ын үзмэрүүдийг дэлгэсэн бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа “Соёмбо чуулга”-ын уран бүтээлчид урлагийн номерыг тус тус толилуулж, хүүхэд, залуучуудад “Тусгаар тогтнол” сэдэвт 12 минутын видео контентыг үзүүлэн ажиллалаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль тогтоомжийг хүртээмжтэй арга хэлбэрээр иргэд, олон нийтэд сурталчлах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлын хүрээнд харьяа нэгжүүдэд зохион байгуулсан.

Алба хаагчийн хэрэгцээ шаардлагад суурилсан сургалтын арга хэлбэрийг нэвтрүүлж, мэргэшсэн чадварлаг хамт олныг төлөвшүүлэх:

Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/59 дүгээр тушаалаар батлагдсан “Согтуурах, мансуурах донтой хүнд албадан эмчилгээ хийхийг хориглох биеийн хүнд эмгэгийн жагсаалт”-д нэмэлт өөрчлөлт оруулж идэвхтэй хэлбэрийн сүрьеэ өвчтэй хүнд албадан эмчилгээ хийхийг хориглох зохицуулалтыг тусгах саналыг холбогдох газарт уламжлан шийдвэрлүүлэх хүсэлтийг хүргүүлсэн.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэгчийг албадан эмчлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн төслийг хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж шийдвэрлүүлэх саналыг 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01/817 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн.

Шийдвэр гүйцэтгэлийн сул орон тоог нөхөн бүрдүүлэх зорилгоор “Шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт”-ыг 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдөр Дотоод хэргийн их сургуулийн компьютер лабораторийн танхимд Е-тестийн системийг ашиглан сорилын шалгалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж, сорилын шалгалтын оноог үндэслэн тэнцсэн оролцогчдыг ярилцлагын шалгалтад хамруулсан.

Шалгаруулалтад нийт 68 оролцогч бүртгүүлснээс 2 оролцогч шалгалтад ирээгүй, товлосон хугацаанд 66 оролцогчийг бүртгэж, шалгалтад хамруулснаас 33 оролцогч сорилын болон ярилцлагын шалгалтын шаардлага хангасан тул Орон тооны бус мэргэжлийн комиссоос шалгалтын дүнг баталгаажуулж, шийдвэр гүйцэтгэгчийн нөөцийн бүртгэлд тэнцсэн оролцогчдыг бүртгэсэн.

ШШГЕГ-ын даргын 2023 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн А/119 дүгээр тушаалаар Шийдвэр гүйцэтгэгчдийн 4-р нэгдсэн зөвлөгөөн, хэлэлцүүлгийг 2023 оны 6 дугаар сарын 22, 23-ны өдөр зохион байгуулсан.

Харьяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн нийт ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгчдийн мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг нэг мөр ойлголтоор хэрэгжүүлэх зорилгоор цахим болон танхимын сургалтыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.

2.3. Мэдлэг, ур чадвар, туршлагад суурилсан, улс төрөөс хараат бус, шударга, ил тод, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлэх, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг сайжруулах талаар

2.3.1. Төрийн алба хаагчийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан ажил, үр дүн, төрийн албан хаагчийг давтан сургах хэрэгцээг судлан хэрэгжүүлсэн ажил, үр дүн

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/215 дугаар тушаалаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад 2022-2023 онд зохион байгуулах сургалтын хөтөлбөр”-ийг батлуулан,

нийт анги, байгууллагуудад хүргүүлж, сар бүр сургалтын тайлан мэдээг авч нэгтгэн, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж байна.

Харьяа анги байгууллага, салбар нэгжүүд сургалтын хөтөлбөрийн дагуу өөрсдийн анги нэгжийн алба хаагчдын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн сургалтын төлөвлөгөө боловсруулж, нэгжийн даргын тушаалаар батлуулан, сургалтыг дараах чиглэлийн хүрээнд зохион байгуулан ажиллаж байна. Үүнд:

- Алба хаагчийн бие бялдрын бэлтгэлжилт, норматив хангах сургалт;
- Цэргийн албаны нийтлэг дүрэм, цэргийн хэргийн мэдлэг олгох сургалт;
- Үндэсний Монгол бичгийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт;
- Гадаад хэл мэдлэгийн түлхүүр сургалт;
- “Зангиа академи”-ийн цахим сургалт;

2023 оны эхний хагас жилийн байдлаар удирдах ажилтнууд, хорих анги, байгууллагын харуул хамгаалалт, гүйцэтгэх ажил эрхэлсэн дэд дарга, цагдан хорих байрны дарга, төлөөлөгч, ахлах төлөөлөгч, ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч, архив, бичиг хэргийн ажилтан, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ажилтнууд, хүний тоо бүртгэлийн байцаагч, туслах, холбоо мэдээллийн технологийн инженерүүд, эмч, эмнэлгийн ажилтнууд зэрэг 10 төрөл мэргэжлийн 696 алба хаагч танхимын болон цахим сургалтад хамрагдсан.

- Хөмрөг үүсгэгч байгууллагуудын архив, бичиг хэргийн ажилтан болон бичиг хэргийн ажил хариуцсан алба хаагчдад Архивын ерөнхий газрын Мэргэжил, арга зүйн удирдлагын газрын архивын баримтын тоо бүртгэл, статистик мэдээ хариуцсан мэргэжилтэн Л.Өнөртуяа сургалт зохион байгуулсан.

Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвтэй хамтран “Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх” сургалтад хотын бүсийн хорих анги, байгууллагуудын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ажилтнууд болон аюулгүй байдал хариуцсан алба хаагчид хамрагдсан.

ШШГЕГ-ын алба хаагчдад Удирдлагын академийн багш нараар Манлайлал, Хүний эрх ба жендэр, Албан бичиг боловсруулалт сэдвүүдээр нийт 15 цагийн сургалт зохион байгуулсан.

Мөн Чингэлтэй дүүргийн онцгой байдлын хэлтэс, Гал унтраах 10 дугаар ангитай хамтран Гал унтраах, гамшгаас урьдчилан сэргийлэх тухай 2 цагийн танхимын сургалт зохион байгуулсан.

2.3.2. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг сайжруулах талаар

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг, Монгол Улсын Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, **Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын дагуу** “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийн нийгмийн хамгааллыг бэхжүүлэх 2021-2024 оны дунд хугацааны хөтөлбөр, төлөвлөгөө”-г боловсруулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/43 дугаар тушаалаар баталж, анги байгууллагад хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээг 2023 оны эхний хагас жилийн байдлаар багцлан дурдвал,

Салбарын эрх зүйн шинэтгэлийг нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн төгөлдөржүүлнэ:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор дараах төрөлжсөн хуулийн төслүүдийг боловсруулан, ХЗДХЯ-нд хүргүүлэн ажиллалаа. Үүнд:

- Иргэн, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийг 3 хэсэг, 15 бүлэг, 138 зүйлтэйгээр боловсруулж, холбогдох танилцуулгын хамт ХЗДХЯ-нд хүргүүлсэн.

- Эрүү, зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийг 7 хэсэг, 18 бүлэг, 169 зүйлтэйгээр боловсруулж, холбогдох танилцуулгын хамт ХЗДХЯ-нд хүргүүлсэн.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тухай хуулийн төслийг 5 бүлэг, 57 зүйлтэйгээр тус тус боловсруулж, хяналтын шатандаа явагдаж байна.

Нийгмийн харилцаа, эдийн засгийн хөгжлийн өөрчлөлттэй үялдуулан салбарын бүтэц, зохион байгуулалт, орон тооны асуудлыг оновчтойгоор шийдвэрлэнэ:

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хорих байгууллагын тогтолцоог бүсчлэн хөгжүүлэх, мансуурах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих түүнтэй тэмцэх урьдчилан сэргийлэх ажил, архи согтууруулах ундааны зохисгүй хэрэглээнээс үүдэлтэй хүн амын эрүүл мэнд нийгмийн аюулгүй байдал, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд Зүүн бүсийн албадан эмчилгээний төв байгуулах болсонтой холбогдуулан нэн шаардлагатай 17 орон тоог харьяа алба, хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн орон тооноос шилжүүлэн авч, Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Зүүн бүсийн албадан эмчилгээний төвийн үйл ажиллагааг эхлүүлээд байна.

Салбарын алба хаагчдын цалин, хөлсний нэмэгдлийг тухайн жилийн инфляцын өсөлт, өндөр хөгжилтэй орны ижил төрлийн байгууллагын түвшинд хүргэнэ.

Алба хаагчдын нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, дэмжлэг үзүүлэх зорилгоор дараах цалин, нэмэгдлийг олгоод байна. Үүнд:

- Аймаг, нийслэлийн төвөөс бусад сум, алслагдсан газарт таван жил тасралтгүй ажилласан алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгож эхэлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар 348 алба хаагчдад 6.8 тэрбум төгрөгийг олгоод байна.

- Хүүхэд асрах чөлөөтэй байгаа алба хаагчдын цэргийн цолны цалин 2023.01.01-ний өдрөөс эхлэн олгохоор шийдвэрлэж, өнөөдрийн байдлаар 206 алба хаагчид 148.2 сая төгрөгийг олгоод байна.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас Хууль зүй, дотоод хэргийн яаманд санал хүргүүлсний дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/363 дугаар тушаалаар ахлагч бүрэлдэхүүний албан

тушаалын зэрэглэлийг “ТТ-7”-оос “ТТ-9” рүү шилжүүлснээр 1254 алба хаагчдад 1.2 тэрбум төгрөг олгосон бөгөөд 1 алба хаагчийн цалин 35 хувиар нэмэгдүүлсэн.

- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/77 дугаар тушаалын дагуу “Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал” буюу гадаадад суралцагчдын зардлаас гадаадын их, дээд сургуулийн бакалавр, адъюнктур, докторантурт ОХУ-ын их сургуульд суралцаж буй 22 алба хаагчид үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэлэг, цолны мөнгө, унааны зардалд 48.9 сая төгрөг олгосон.

Салбарын алба хаагчдын дүрэмт хувцас, зэвсэг, тусгай хэрэгсэл, тусгай зориулалтын техник хэрэгслийн чанар, стандартыг судлан тогтоож, лаборатори, үйлдвэр байгуулна

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 2023 оны худалдан авах ажиллагааны батлагдсан төлөвлөгөөний дагуу тус ерөнхий газрын даргын 2023.04.12-ны өдрийн “Гэрээ байгуулах эрх олгох тухай” А/88 дугаар тушаалаар 407, 409, 445 дугаар хорих ангиуд, “Газар-Ивээл” ТӨААТҮГ, “Хилийн цэргийн 0288 дугаар анги” ТӨААТҮГ-тай нийт 694.9 сая төгрөгийн цэргийн алба хаагчийн хувцас, хэрэглэлийг үйлдвэрлэн нийлүүлэхээр шийдвэрлэсэн. Мөн “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу зарим хувцас, хангалтын материалыг нийлүүлэх нээлттэй тендер зарлан, холбогдох журмын дагуу шалгаруулж, шалгарсан 7 аж ахуйн нэгжүүдтэй нийт 551.3 сая төгрөгийн гэрээг байгуулсан.

Тайлант хугацаанд 18 нэр төрлийн 70.3 сая төгрөгийн цэргийн дүрэмт хувцас, хэрэглэлийг алба хаагчдад олгоод байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, алба хаагчдын ажиллаж, амьдрах орчин нөхцлийг сайжруулах арга хэмжээг зохих түвшинд хэрэгжүүлэн ажиллаж байна.

Гурав: Бусад ажил:

3.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх ажлын хүрээнд:

Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын радио холбоог шинэчлэх төслийг хэрэгжүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/237 дугаар тушаалаар байгуулсан “Төрийн тусгай чиг үүргийн байгууллагуудын хэт богино долгионы радио станцуудыг шинэчлэх чиг үүрэг бүхий Дэд ажлын хэсэг”-ээс өгсөн үүргийн дагуу яамны харьяа агентлаг, тусгайлсан чиг үүрэгтэй байгууллага (ЦЕГ, ХХЕГ, ШШГЕГ, ШШЕГ)-уудын богино болон хэт богино долгионы радио холбоог шинэчлэхэд шаардлагатай 47.0 сая ам.долларын нэгдсэн тооцоо, судалгааг гаргаж, танилцуулгыг 2022.03.11-ний өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамны Дэд сайд, Мэдээлэл, технологийн газрын дарга нарт хүргүүлсэн.

Дээрх төслийн эхний үе шатыг АНУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн 12.0 сая ам.долларын санхүүжилтээр “Моторола сольюшн” компанитай хамтран хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд АНУ-ын Конгрессоос 2022 онд эхний 5.0 сая ам.долларын санхүүжилтийг баталж, 7.0 сая ам.долларын буцалтгүй тусламж эцэслэн батлагдаагүй байна.

АНУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн 12.0 сая ам.доллар бүрэн шийдвэрлэгдсэнээр төслийн эхний үе шат буюу Улаанбаатар хотод үндсэн дэд

бүтцийн суурийг 50.0 хувьтай байгуулж, цагдаагийн байгууллагын хэрэгцээт радио станцын 30.0 хувьд хангалт хийгдэх бөгөөд энэ оны 3 дугаар улирлаас хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Хоригдогсдын бүртгэл хяналтын нэгдсэн системийг шинэчлэх ажлын хүрээнд Улсын Ерөнхий Прокурорын газрын дотоод үйл ажиллагааны систем, цахим бүртгэлтэй танилцаж мэдээлэл солилцсон.

Мөн Азийн хөгжлийн банкны ТД56013001 дугаартай Хууль зүйн салбарын “Хууль зүй мэдээллийн удирдлагын чадавхыг бэхжүүлэх төсөл”-д хамрагдаж, хамтран ажиллах гэрээг байгуулан, систем шинэчлэх ажлыг эхлүүлсэн.

Азийн хөгжлийн банкнаас зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд ашиглагдаж байгаа цахим хяналтын системийн программ хангамжийн хөгжүүлэлт, өргөтгөлийн ажилд шаардлагатай 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэх зорилгоор “Цахим хяналт, удирдлагын төвийн программ хангамж, серверийн хөгжүүлэлт, өргөтгөлийн ажлын төсөл”-ийн саналыг боловсруулан, Хууль зүй, дотоод хэргийн яамны Мэдээллийн технологийн газарт хүргүүлж, удирдлагын түвшинд 1.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийн шийдвэрийг гаргуулан, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас төсөл хэрэгжүүлэгч компанийг сонгон шалгаруулах “Нээлттэй тендер”-ийг зарласан.

Цахим хяналт, удирдлагын төвийн алба хаагчид “СЭТТЭ” ХХК-ийн инженерүүдтэй хамтран шинэ төрлийн гар болон хөлийн цахим бугуйвчийг хяналтын системд тохируулах ажлыг хийсэн. Өнөөдрийн байдлаар “BTGT” ХХК-ийн инженерээр хяналтын системийг шинэчлэх программыг бичүүлэх ажлыг эхлүүлээд байна.

Зорчих эрхийг хязгаарлах хяналтын системд шинэчлэл хийгдэж байгаатай холбогдуулан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Монгол Улсын нарийвчилсан масштабтай байр зүйн 1:100000, хот суурин газрын 1:10000 масштаб бүхий зургийн ашиглагдаж байгаа сүүлийн хувилбарыг цахим хэлбэрээр гаргуулан авахаар албан бичгээр хандсан.

Цахим хяналтын дэд төвийг өргөтгөн байгуулахад шаардлагатай 180.2 сая төгрөгийн санхүүжилтийг “Азийн хөгжлийн банк”-ны 1.6 тэрбум төгрөгийн буцалтгүй тусламжаас шийдвэрлүүлэх саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын II байранд Цахим хяналтын дэд төвийг тохижуулж, засвар үйлчилгээ хийсэн бөгөөд шаардлагатай тоног төхөөрөмж, сервер, техник хэрэгслийг худалдан авах нийлүүлэгчийг сонгон шалгаруулах “Нээлттэй тендер”-ийг зарлаад байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамны мэдээллийн технологийн газарт 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 04/1260 дугаар албан бичгээр Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар хэрэгжих төслийн явцын талаарх мэдээллийг ирүүлэх талаар хүсэлт хүргүүлсэн.

Харьяа газар, хэлтсээс ирүүлсэн эвдрэл гэмтэлтэй нийт 368 ширхэг хяналтын цахим бугуйвчийг “Бодь-Электроникс” ХХК-д дүгнэлт гаргуулахаар хүргүүлсэн. Үүнээс 69 ширхэг цахим бугуйвчийг хэрэглэгчийн буруутай үйлдэл, дахин ашиглах боломжгүй, 68 ширхэг нь баталгаат хугацаа дууссан гэх шалтгаанаар ирүүлсэн, өмнөх оны үлдэгдэлтэй нийт 234 ширхэг цахим бугуйвч байна.

“Бодь Электроникс” ХХК-аас 69 ширхэг цахим бугуйвч хэрэглэгчийн буруутай үйлдэл, дахин ашиглах боломжгүй актлагдах дүгнэлттэй ирснээс 32 ширхэг цахим бугуйвчийг сэлбэн засварлаж газар хэлтсүүдэд хүлээлгэн өгсөн.

Нөөцөд иж бүрэн шинэ цахим бугуйвч 10, ашиглаж байсан хуучин цахим бугуйвч 3, ашиглаж байсан хуучин хөлийн цахим бугуйвч 1, шинэ төрлийн DDX-04 загварын гарын цахим бугуйвч 262, DDX-14 загварын хөлийн цахим бугуйвч 10 нийт 276 ширхэг цахим бугуйвч, зөөврийн цэнэглэгч 53, энгийн цэнэглэгч 523, соронзон цэнэглэгч 86 ширхэг, бугуйвчийн оосор 42 ширхэг, дэлгэц 73 ширхэг, батерей 20 ширхэг тус тус байна.

Албаны тоон гарын үсгийн гэрчилгээ олгох, сунгах, түр түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох чиг үүргийг зохицуулах тухай хамтран ажиллах гэрээг “Тридум Э-Секьюрити” ХХК-тай 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан.

Байгууллагын дотоод үйл ажиллагаанд албаны тоон гарын үсгийг 92 удирдах алба хаагч, 75 шийдвэр гүйцэтгэгч, нийт 165 алба хаагчдад тоон гарын үсгийн гэрчилгээ, е-токен төхөөрөмжийн хамт ашиглаж байна.

Байгууллагын хэмжээнд албан хэрэг хөтлөлт, архивын системийн баталгаажуулалтыг албаны тоон гарын үсэг ашиглан явуулах зорилгоор 165 удирдах албан тушаалтанд тоон гарын үсгийн гэрчилгээ, токен төхөөрөмжийг олгосон.

Албаны тоон гарын үсгийн токен төхөөрөмжийн гэрчилгээг 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 47 удирдах алба хаагчдад шинээр болон шилжүүлэн олгоод байна.

2023 оноос Архивын ерөнхий газартай хамтран Төрийн архивын (www.e-document.gov.mn) системийг Тусгай архивын үйл ажиллагаанд шинээр нэвтрүүлж, 5 алба хаагчдад системд нэвтрэх, ашиглах эрх олгосон. Уг системд 2023 онд удирдлагын баримтын 40 хувь буюу 255.997 хуудас 2599 баримтыг шилжүүлсэн байхаар төлөвлөсөн бөгөөд тайлант хугацаанд 22.594 хуудас 237 баримтыг цахим системд шилжүүлж, гүйцэтгэл 5.7 хувьтай хэрэгжсэн.

Хуучин ашиглаж байсан архивын программд холбосон, скайнердсан баримтыг эх баримттай тулгах, нягтлан шалгах, суурь түвшин тогтоох ажлыг эхлүүлсэн бөгөөд гүйцэтгэл 8.9 хувьтай хэрэгжиж байна.

- Ньюсоник ХХК-ны “EDOC” архив, албан хэрэг хөтлөлтийн системийг хөмрөг үүсгэгч 53 байгууллагад 2022 оноос шинээр нэвтрүүлж, Мэдээлэл технологийн хэлтсээс <https://edoc.mojha.gov.mn/> системд нэвтрэх хаяг, эрх олгон, 2023 оноос үйл ажиллагаандаа ашиглаж байна. Мөн шинээр нэвтрүүлж буй “Edoc” системийн хүрээнд “Албан хэрэг хөтлөх системийн модуль”, “Архивын системийн модулийн ашиглалт, нэвтрүүлэлт” сэдвээр архив, бичиг хэргийн ажилтнуудад цахим болон танхимын сургалтыг 2 удаа зохион байгуулж ажилласан.

2023 оны эхний хагас жилийн байдлаар ШШГЕГ-ын цахим хуудсаар дамжуулан онлайн захилга 51, захиалгын хуудсаар 261, нийт 312 иргэн, алба хаагчаас архивын захиалга хүлээн авч, 297 хүсэлтийг шийдвэрлэсэн. Үүнээс лавлагаа-253, цалингийн тодорхойлолт-8, архивын тодорхойлолт-3, 67 иргэн, алба хаагчдад 604 хуудас баримтын хуулбар тус тус олгосон. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад архивын захиалга 29.1 хувиар, архивын үйлчилгээ үзүүлсэн байдал 39 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

3.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/126 дугаар тушаалаар “ШШГБ-ын Жендэрийн асуудал хариуцсан дэд зөвлөл”-ийг шинэчлэн баталсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлыг хууль, журмын хүрээнд зохион байгуулан ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд нийт алба хаагчдын 35.6 хувийг эмэгтэй алба хаагчид эзэлж байна.

Дотоод хэргийн их сургуулийн 2022-2023 оны хичээлийн жилд Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн бакалаврын хөтөлбөрт 68 иргэн, эчнээ ангид 9, магистрт 4, докторт 1, ОХУ-ын ДХЯ-ны харьяа их, дээд сургуулийн бакалаврын хөтөлбөрт 12 эмэгтэй алба хаагчийг байгууллагын захиалгаар тус тус суралцуулж байна.

Шалгуур үзүүлэлт хангасан 44 эмэгтэй алба хаагчийг албан тушаалд дэвшүүлэн томилсон. /удирдах бие бүрэлдэхүүнд 2, ахлах албан тушаалд 11 /ахлах мэргэжилтэн, ахлах шийдвэр гүйцэтгэгч, ахлах нягтлан бодогч, ахлах тогооч гэх мэт/, бусад албан тушаалд 31 байна/

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг харьяа хорих анги, байгууллагад хүргүүлсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын жендэрийн дэд зөвлөлийн ээлжит хуралдааныг 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулж, хийж хэрэгжүүлсэн ажлаа дүгнэн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтэд анхаарч ажиллах чиглэл өгсөн.

Байгууллагын хэмжээнд удирдах албан тушаалтнуудад “Ажлын байрны бэлгийн дарамт”, алба хаагчдад “Жендэрийн эрх тэгш байдал, хүний эрх”, “Ажлын байран дахь жендэрийн эрх тэгш байдал”, Жендэрт суурилсан хүчирхийлэл”, “Гэр бүлийн хүчирхийлэл”, “Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт”, “Жендэрийн мэдрэмжтэй хүний нөөцийн удирдлагын зарим асуудал, шийдэл”, “Хүний эрх, ажлын байрны дарамтын тухай үндсэн ойлголт, хэм хэмжээ”, “Хүний эрх ба Жендэрийн тэгш байдал”, “Ажлын байрны бэлгийн дарамт”, “Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал”, “Ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх, үл тэвчих орчинг бүрдүүлэх”, “Жендэрийн хэвшмэл ойлголт”, “Жендэрийн тухай ойлголт, хүйсийн ялгаатай байдлыг хүндлэх соёлыг төлөвшүүлэх нь”, Байгууллагын үйл ажиллагаанд жендэрийн дүн шинжилгээ хийх нь” зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгуулж, жендэрийн талаарх мэдлэгийн түвшинг нэмэгдүүллээ.

“Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт”, “Жендэрийн мэдрэмжтэй хүний нөөцийн удирдлагын зарим асуудал, шийдэл”, “Хүний эрх, ажлын байрны дарамтын тухай үндсэн ойлголт, хэм хэмжээ” сэдвээр Удирдлагын академийн Төрийн удирдлагын тэнхимийн багш доктор /Ph.D/ дэд профессор Э.Ариунаа, Ч.Эрдэнэчимэг нар нийт алба хаагчдад сургалт зохион байгуулсан.

Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулсан сургагч багш бэлтгэх сургалтад 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн Сургалт, хүний нөөц,

хэвлэл мэдээлэл, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, дэслэгч Б.Халиун хамрагдаж, Гэрчилгээ авсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь жил бүр "Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 өдрийн аян"-нд нэгдэж ирсэн. Тухайлбал, 2021 онд "МАНЛАЙЛАГЧ БАЙЦГААЯ: ХҮЧИРХИЙЛЛИЙН ЭСРЭГ ТУУШТАЙ ЗОГСОЖ, ДУУ ХООЛОЙГОО ӨРГӨӨ", 2022 онд "НАНДИН БҮХНЭЭ ХАМГААЛЬЯ-ӨӨРИЙГӨӨ, ГЭР БҮЛЭЭ, ОРЧИН ТОЙРНОО", 2023 онд "НАДААС, ТАНААС, БИДНЭЭС ЭХЛЭЛТЭЙ" уриалгад тус тус нэгдэж, энэ чиглэлээр сургалт зохион байгуулж, богино хэмжээний шторк, мэдээллийг бэлтгэн байгууллагын цахим сайтад байршуулж, олон нийтэд түгээсэн. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанаас "Төрийн цэргийн байгууллагын болон цагдаагийн эмэгтэй алба хаагчдын оролцоог энхийг дэмжих ажиллагаа, аюулгүй байдлын салбар нэмэгдүүлэх боломж" сэдэвт захиалгат төслийн хүрээнд хийгдэж буй "Төрийн цэргийн болон цагдаагийн байгууллагын эмэгтэйчүүд энхийн үйлдсэд" сэдэвт эрдэм шинжилгээний нэгдсэн хуралд "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эмэгтэй алба хаагчид энхийн үйлдсэд" сэдвээр илтгэл тавьсан. Ингэснээр энхийг дэмжих ажиллагаанд тус байгууллагын эмэгтэй алба хаагчдын оролцоог нэмэгдүүлэх боломжийг нээж өгсөн.

Тухайлбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь эмэгтэй алба хаагч олонтой, төрөл мэргэжил бүрт эмэгтэй алба хаагчид үүрэг гүйцэтгэх боломжтой, судалгаанд оролцсон эмэгтэй алба хаагчдын 71.9 хувь нь энхийг дэмжих ажиллагаанд оролцох хүсэлтэй байсан ба жилд дунджаар эмнэлгийн мэргэжлийн ажилтнаар 2, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчээр 2, холбоочин мэргэжлээр 1, бусад төрлийн мэргэжлээр 5 /эрх зүй, санхүүгийн ажилтан, тоо бүртгэл, хүний нөөц/ эмэгтэй алба хаагч оролцох боломж бүрдэж байгаа юм.

"Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг тохиолдуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын "Эмэгтэйчүүдийн зөвлөл" Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөлтэй "Хамтран ажиллах санамж бичиг" байгууллаа. Санамж бичгийн хүрээнд тус байгууллагын эмэгтэй алба хаагчдын нийгмийн харилцаан дахь манлайлал, оролцоог нэмэгдүүлэх, өөрийгөө хөгжүүлэх боломжийг олгохын зэрэгцээ боловсролын чиглэлээр төсөл хөтөлбөр хамтран хэрэгжүүлж, харилцан мэдээлэл солилцохоор шийдвэрлэсэн.

Санамж бичгийн хүрээнд англи хэлний зохих мэдлэгтэй, БНХАУ-ын их дээд сургуульд тэтгэлэгээр суралцах хүүхдүүдийн судалгааг авч, сонгон шалгаруулах ажлыг зохион байгууллаа.

Монголын залуучуудын холбооны дэргэдэх Эмэгтэйчүүдийн холбооноос зохион байгуулсан Анхдугаар чуулганд 10 эмэгтэй алба хаагч оролцсон.

3.3. 2023 оны эхний хагас жилийн байдлаар 150 алба хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газраар хянуулж, дүгнэлт гаргуулан, 143 алба хаагчийг албан тушаалд томилж, тодорхой шалтгааны улмаас албан тушаалд томилогдоогүй 7 алба хаагч байна.

3.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд, олон нийтийг хэрэгцээт мэдээ, мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх, алба хаагчдын ажил албаны онцлог, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор нэвтрүүлэг, сурвалжилга, ярилцлага, богино хэмжээний видео, шторк, постер зэргийг бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон социал орчинд түгээн ажиллаж байна.

Шинэчлэн батлагдаж, 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд тус хуулийн 8 дугаар зүйлд 68 төрлийн мэдээллийг ил тод, нээлттэй болгохоор заасан ба мэдээллийг ил тод болгосон эсэхийг тодорхойлох 98 шалгуур үзүүлэлтийн дагуу холбогдох мэдээллүүдийг cd.gov.mn цахим хуудаст байршуулж, хэрэгжилтийг Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн бөгөөд тус яамны <https://shilen.gov.mn/> сайтад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар **98.70** хувиар үнэлэгдэж, агентлагуудаас долдугаар байрт жагсаж байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд харьяа анги, байгууллага, салбар нэгжүүдэд нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах тухай үүрэг чиглэлийг 05/1266 дугаар албан бичгээр хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Иргэд, олон нийтийн санаа бодолд дүн шинжилгээ хийх, удирдлагыг мэдээллээр хангах, хүрээнд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд нийтлэгдсэн байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчтай холбоотой зэрэг, сөрөг болон нийгэмд өрнөж буй цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийн тоймыг **110** удаа бэлтгэн танилцуулсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааг хөгжүүлэх 2021-2024 оны дунд хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/42 дугаар тушаалаар батлуулж, биелэлтийг ханган ажиллалаа. Үүнд:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын www.cd.gov.mn сайтад 76, фэйсбүүк хуудаст 210, дотоод мэдээллийн самбарт 68 мэдээ мэдээллийг тус тус байршууллаа. Цахим хуудаст давхардсан тоогоор 162921 удаагийн хандалт хийгдсэн байна.

- Байгууллагын албан ёсны cd.gov.mn сайтад шаардлагатай цэсийг нэмж баяжилт хийх хүрээнд “Төрийн мэдээлэл” цэсэнд эмхэтгэлийн 21 дугаар, “Албадан дуудлага худалдаа” цэсэнд 20 зарыг тус тус нэмэлт цэс үүсгэж байршуулсан.

Мөн Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 96 дугаар тогтоолын хавсралт “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-т заасны дагуу байгууллагын цахим хуудаст нийтэлж байгаа мэдээг крилл, монгол бичгээр хослуулан хөрвүүлж байршуулж хэвшүүлсэн.

- “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага” фэйсбүүк хуудасны дагагч өдрийн байдлаар 44411 байгаа бөгөөд тус тоон үзүүлэлтийг өмнөх оны жилийн эцсийн байдалтай харьцуулахад 3803 дагагчаар нэмэгдсэн.

Мөн мэдээ мэдээллийн агуулга, хүртээмж, ач холбогдлыг сайжруулах, гарч болохуйц сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх зорилгоор харьяа анги, байгууллага, салбар нэгжийн хэмжээнд бэлтгэн түгээж буй мэдээ мэдээлэл, контент, нэвтрүүлэг, постер, шторк зэргийг урьдчилан хянаж, редакторлан, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч нийтлэх зөвшөөрөл өгч хэвшүүлсэн.

Тайлант хугацаанд харьяа анги, байгууллага, салбар, нэгжийн хэмжээнд зохион байгуулагдсан арга хэмжээ, үйл явдлын нийт 84 мэдээг хянаж, редакторлан нийтлэх зөвшөөрөл олгож ажиллалаа.

Хэвлэл мэдээллийн төвөөс дотооддоо “Албаны төлөө” нэвтрүүлэг 3, видео мэдээ 5, шторк 21, постер 53, подкаст 3, фото сурвалжилга 1, нийтлэл 1, сурвалжилга 1 дугаарыг тус тус бэлтгэн олон нийтэд хүргэсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаа болон байгууллагаас зохион байгуулсан “Эерэг харилцаа, шуурхай үйлчилгээ”, “Хуулиа дээдэлж, үүргээ биелүүлье”, “Хүүхдийн тэтгэлэг-хүүхдийн ирээдүй”, “Халтиргаагүй орчин, хариуцлагатай байгууллага”, “Дүрэмт хувцас бидний бахархал, дүрмээр өмсөх бидний үүрэг” аяны хүрээнд МҮОНРТ, TV5, TV8, NTV, C1, TV6, Eagle.mn, TV25, TV9 телевизийн нэвтрүүлэг 6, зочны ярилцлагын цагт 6, мэдээг 51 удаа давталттайгаар;

“Өдрийн сонин”, “Өнөөдөр”, “Зууны мэдээ”, “Өглөөний сонин” сонинд 12 мэдээ мэдээлэл;

Олон нийтийн zaluucom.mn, check.mn, urug.mn, unuudur.mn, tac.mn, tsahiur.mn, onlinetv.mn, zarig.mn, gogo.mn, montsame.mn, isee.mn, eagle.mn, erennews.mn, medee.mn, unen.mn, etime.mn, arslan.mn, eguur.mn, niitlel.mn, snews.mn, news.mn, ubn.mn, 24 tsag.mn, post.mn, ikon.mn, zindaa.mn, dardas.mn сайтад нийт сурвалжилга 9, ярилцлага 23, мэдээ мэдээлэл 140 тус тус нийтлүүлсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчтай холбоотойгоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон олон нийтийн сүлжээнд нийтлэгдсэн бодит бус, сөрөг мэдээ мэдээлэлд нийт 9 удаа хариу залруулга, тодруулга, тайлбар мэдээллийг давхардсан тоогоор 77 удаагийн давтамжтайгаар хэвлэл мэдээллийг байгууллагад өгч ажилласан.

3.5. Ногоон хөгжлийг дэмжиж “100 сая мод” хөдөлгөөн өрнүүлэх арга хэмжээний хүрээнд:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нийт бие бүрэлдэхүүн нэгдэж, “100 сая мод” хөтөлбөрийн хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь 100 сая мод тарих хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2023 оны эхний хагас жилийн байдлаар хаврын мод тариалалтын ажлын хүрээнд 647,562 ширхэг харандан үрсэлгээ, тарьц, суулгац, жимс жимсгэнэ, хайлаас, шар хуайс, чацарганы модыг тус тус суулгасан.

100 сая мод тарих ажлын хүрээнд 10 хорих анги, байгууллага нь 65 га газарт мод үржүүлгийн орчныг бий болгоод байна.

417 дугаар нээлттэй хорих анги, 439 дүгээр хаалттай хорих ангиуд нь мод үржүүлгийн газрын тусгай зөвшөөрөл аваад байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулсан.

Санамж бичгийн хүрээнд мод тарьж ургуулах, арчлах чиглэлээр алба хаагчдад сургалт зохион байгуулах, Говийн болон Хангайн бүсэд мод тарьж ургуулах, арчлах, хашаа, хамгаалалт барих, ойн зурвас байгуулах зэрэг олон ажлыг хамтран хийж хэрэгжүүлэхээр тогтлоо.

4. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах асуудлаар зөвлөгөө өгч, ажилласан байдал, үр дүн

ШШГЕГ-ын харьяа хорих анги, байгууллагын Сахилга, ёс зүйн салбар хороо нь алба хаагчдын дунд сургалт зохион байгуулах, тэдний албан үүрэг гүйцэтгэлт, сахилга, ёс зүй, хариуцлага, сонор сэрэмжийн байдалд хяналт тавин, илэрсэн зөрчлийг засуулахаар зөвлөмж, дүгнэлт өгөх зэрэг арга хэмжээгавч ажиллажээ. Тухайлбал;

-401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг “Дүрэмт хувцас бидний бахархал, дүрмээр өмсөх бидний үүрэг” аяны хүрээнд “Сахилга хариуцлагатай, цэрэгжилт жагсаалч хамт олон” “Цэргийн нийтлэг дүрмүүд”, “Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм”-ийн дагуу алба хаагчдыг цэргийн дүрэмт хувцсыг өмсөж хэвшүүлэх, сахилга хариуцлагатай, цэрэгжилт жагсаалч хамт олныг шалгаруулах зорилгоор хорих ангийн хэмжээнд зохион байгуулж ажилласан. Сахилга, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж, таслан зогсоох зорилгоор “Ёс журмын эргүүл” ажиллуулж байна. Сахилга, ёс зүйн дүрэм, цэргийн дүрэмт хувцас өмсөх, цэргийн дотоод албаны дүрэм, жагсаалын үндсэн ажиллагаа сэдвээр Зэвсэгт хүчний 013 дугаар ангитай хамтран “Цэргийн нийтлэг дүрмүүд”-ээр хичээл сургалт (онол, практик), хэлбэрээр зохион байгуулж нийт алба хаагчдыг хамруулсан. Салбар ёс зүйн хороо сар бүрийн 3 дахь долоо хоногийн Пүрэв гарагт хуралдаж хэвшсэн.

-Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-437 дугаар нээлттэй хорих анги “Дүрэмт хувцас бидний бахархал, дүрмээр өмсөх бидний үүрэг” аяны хүрээнд олон нийтийн цахим сүлжээнд цахим нөлөөллийн контентыг хийж олон нийтэд сурталчилж ажилласан. Зэвсэгт хүчний 0186 дугаар ангитай хамтран “Цэргийн шинэчлэгдсэн дүрэм”-ээр хичээл сургалт орж авсан мэдлэгээ бататгах цэргийн хэргийн мэдлэг, танин мэдэхүйн асуултаар “АХА” хөгжөөнт тэмцээн зохион байгуулсан. Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн төвийн сургалт хариуцсан менежер Б.Отгонхишиг “Манлайлал”, ХЭҮК-ын ахлах мэргэжилтэн Ц.Батзаяа “Хүний эрхийн үндсэн ойлголт”, Орхон аймгийн Цагдаагийн газрын ахмад У.Дэлгэрхишиг, ахлах дэслэгч Н.Ганчагт нар “Хар тамхи, мансууруулах сэтгэцэд нөлөөт бодис”, Орхон аймгийн Насан туршийн боловсролын төвийн багш Д.Буянхишиг “Гэр бүлийн эерэг харилцаа, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд анхаарах асуудал” сэдвээр тус тус сургалтыг зохион байгуулж ажилласан.

-439 дүгээр хаалттай хорих анги Алба хаагчдын ёс зүйг дээшлүүлэх, эерэг харилцаа хандлагыг бий болгох, ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Ёс зүйг алба хаагчдадаа сурталчилъя” зурагт хуудас /баннер/-ыг бэлтгэн сахилга ёс зүйн хорооны хүндэт самбар, хэрэглэгчийн булан, хурлын танхим зэрэгт байрлуулан, 2023 оны 2 дугаар улирлын “Хамгийн ёс зүйтэй алба хаагч”-ийг шалгаруулж, зургийг хүндэт самбарт байршуулсан.

Нийт алба хаагчдаас google forms программ ашиглан “Сэтгэл ханамжийн судалгаа” авахад ёс зүйн зөрчилтэй, харьцааны доголдолтой, ёс зүйгүй харьцаж буй албан тушаалтныг нэрлэнэ үү гэх нээлттэй асуулгад 10 алба хаагчийн нэр дурдагдсаныг ангийн даргын Зөвлөлийн хуралд танилцуулан, ангийн даргын зүгээс ёс зүй, харилцаа хандлагаа сайжруулах, дахин зөрчил дутагдлыг гаргалгүй ажиллах талаар анхааруулга өгч, нийт алба хаагчдад хамт олны дунд нийтэч, эвсэг байдлыг бүрдүүлэх, ёс зүй, харилцаа хандлагаа сайжруулах талаар яриа таниулга хийж ажиллаа. Булган аймгийн Цагдаагийн газартай хамтран “Кибэр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Замын хөдөлгөөний дүрэм”, “Гэр бүлийн хүчирхийлэл, зөрчлийн хэрэгт холбогдохын хор уршиг” сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулсан.

-Төв аймаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар Алба хаагчдын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд сахилга хариуцлагын чиглэлээр “Алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрэм”, “Үйлчилгээний стандарт”, “Албаны бэлэн байдал”, “Ажлын цаг ашиглалт”, “Төрийн болон албаны, хувь хүний нууцын тухай хууль”, “Удирдах дээд газраас ирүүлж буй үүрэг чиглэл”, “Цахим мэдээллийн аюулгүй байдал” болон өөрийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр заалтыг тусгуулан хэрэгжилтийг ханган ажилласан. 2023 онд “БИД ЁС ЗҮЙТЭЙ ХАМТ ОЛОН” уриалгыг дэвшүүлсэн байна.

Нийт алба хаагчдын саналаар газрын “ХАМГИЙН ХАМГИЙН”-г шалгаруулан өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагнаж, урамшуулсан. Үүнд: “Хамгийн ёс зүйтэй алба хаагч”, “Хамгийн ажлын цаг ашиглалт сайтай алба хаагч”, “Хамгийн цэрэгжилт, жагсаалч байдал сайтай алба хаагч”, “Хамгийн цэргийн дүрэмт хувцсыг дүрмийн дагуу цэвэр үзэмжтэй өмсдөг алба хаагч”.

Мөн алба хаагчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, ажилдаа дур сонирхолтой болгох зорилгоор сар бүр байгууллагын “Онцлох алба хаагч” нарыг шалгаруулан байгууллагын пэйж хуудас болон албаны коридорт байрлах “УХААЛАГ САМБАР”-т нэг сарын турш байрлуулан алдаршуулж байна.

Алба хаагчдын эрх зүйн мэдлэг, хувь хүний хөгжил, ёс зүй, хандлагыг дээшлүүлэх сэдвүүдийн хүрээнд зохион байгуулсан сургалтаас авсан мэдлэгийг бататгах, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх, хамт олонч уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор “ЦЕНТАВР” танин мэдэхүйн тэмцээнийг зохион байгуулсан.

Хүний эрхийн үндэсний комиссын Төв аймаг дахь референт У.Чойжилсүрэнтэй хамтран “Төрийн алба хаагчийн ёс зүй ба хүний эрх” сэдвээр танхимын сургалт зохион байгуулсан.

-Хэнтий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-419 2023 оны нэгдүгээр улиралд сахилга, ёс зүйн зөрчил гаргаж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын болон ангийн даргын тушаалаар сахилгын арга хэмжээ авагдсан 7 албан хаагчид “ШААРДЛАГА”, ангийн сахилга, ёс зүйн салбар хорооны хурлаар сахилгын асуудал гарган сахилгын талонд сануулах арга хэмжээ авагдсан нэр бүхий 18 албан хаагч нарт “ЗӨВЛӨМЖ”, 2022 онд сахилгын арга хэмжээ авагдаж байсан боловч дахин сахилга, ёс зүйн зөрчил гаргалгүй ажиллаж байгаа 7 алба хаагчид “ТАЛАРХАЛ” гардуулсан. Алба хаагчдын дунд танин мэдэхүйн асуулт хариулттай “АХА” тэмцээнийг зохион явуулжээ.

- 433 дугаар хаалттай хорих анги хамгаалалтын ажилтан, ахлах ахлагч В.Чинбаатар нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад 13 жил ажиллах хугацаанд сахилга ёс зүйн зөрчил гаргалгүй ажилласан тул байгууллагын “Сахилга хариуцлага”-тай алба хаагчаар шалгаруулж, дурсамж үнэ бүхий зүйлээр шагнаж урамшуулж

-Хэрэм цамхаг УТҮГ алба хаагчдын ажлын хариуцлагыг дээшлүүлэх, зөрчил дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2023 оны 02 дугаар улиралд “ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛ, ЭЕРЭГ ХАРИЛЦАА” зорилтыг дэвшүүлж, зорилтын хүрээнд: Хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ нэр төртэй биелүүлэх, Эерэг харилцаатай, ёс зүйн зөрчилгүй хамт олон болох, Бүтээгдэхүүний чанар, стандартыг ханган ажиллах дэд зорилтуудыг дэвшүүлэн, зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Мөн алба хаагчдын харилцаа хандлага, ёс зүйг дээшлүүлэх үүднээс “Эвсэг-Нийтэч хамт олон” аяныг зохион байгуулж байна. Аяны хүрээнд: Мэндчилгээ, Өглөөний цай, Спорт өдөрлөг, Бүлгийн ярилцлага, Хөгжөөнт тоглоом зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажиллаж байгаа нь алба хаагчдын харилцлаа хандлага, ёс зүйг дээшлүүлэхэд чухал ач холбогдол өгч байна.

-Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги 2022-2023 оны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилготой 70 хувийг танхимаар 30 хувийг цахим болон практик байдлаар зохион байгуулсан.

Зангиа академийн байгууллагын багц сургалтыг нийт алба хаагчдад цахим хэлбэрээр тогтмол зохион байгуулсан. Зангиа академийн 65 төрлийн цахим сургалтад нийт 151 алба хаагч хамрагдаж, давхардсан тоогоор 37 сургалтын гэрчилгээ авсан байна.

-435 дугаар хаалтай хорих анги Дотоод хэргийн их сургуулийн харьяа Ахлагчийн мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвөөс зохион байгуулсан эрдэм шинжилгээний хуралд “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ахлагч бүрэлдэхүүнд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдвээр илтгэл хэлэлцүүлж дэд байр эзэлсэн байна.

-Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар Ёс зүй, сахилгын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, байгууллагын хэмжээнд мөрдөгдөж буй ёс зүй сахилга дэг журмыг сахиулахад чиглэгдсэн эрх зүйн актуудыг алба хаагчдад судлуулах зорилгоор Төрийн албаны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ёс зүйн дүрэм, үйлчилгээний стандарт, цэргийн дүрэм зэрэг эрх зүйн актуудыг багтаасан 30 асуулт, Авлигын эсрэг хууль, Эрүүгийн хууль, Нийтийн албанд болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль эрх зүйн актуудыг багтаасан 50 асуулт бүхий тест боловсруулж, нийт 182 алба хаагчаас тестийн шалгалт авснаас 90 дээш буюу “А” үнэлгээтэй 32 албан хаагч, 80-90 буюу “В” үнэлгээтэй 66 албан хаагч, 70-80 буюу “С” үнэлгээтэй 46 албан хаагч, 60-70 буюу “D” үнэлгээтэй 17 албан хаагч тус тус дүгнэгдсэн байна.

-СМДӨАЭАХХГ Алба хаагчдыг зөрчил дутагдал гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор дараах 5 төрлийн баталгаа авч ажиллажээ. Үүнд: “Архигүй монголын төлөө хамтдаа”, Архидалтгүй хөтөлбөр”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх”, “Төрийн болон албаны нууцын тухай хууль”, “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Монгол улсын засгийн газрын 2018.08.22-ны өдрийн 258-р тогтоол, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх” баталгааг тус тус авч ажилласан.

-Төв аймаг, Мөнгөнморьт сум дахь 417 дугаар анги Сахилга, ёс зүйн хорооны үйл ажиллагааг дэмжих, байгууллагын соёлыг дээшлүүлэх, цэргийн алба хаагчийн захирах, захирагдах ёсыг хэрэгжүүлэх, төрийн алба хаагчийн эрхэмлэх зүйл, байгууллагын ажилтны үйлчилгээний стандартыг хангуулах чиглэлээр “Ёс зүйн эргүүл”-ийг ангийн эргүүлийн офицерт давхар хариуцуулан ажиллуулж сахилга, ёс зүйн шаардлагыг ханган ажиллаж байна.

Ангийн бие бүрэлдэхүүний сахилга хариуцлагыг дээшлүүлэх, ёс зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн нэг сарын хугацаатай “Талархал”-ын аяныг зохион явуулсан.

-Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар “Би хуулиа дээдлэгч, ёс зүйтэй алба хаагч” сэдэвт “АХА” тэмцээнийг алба хаагчдын Үндсэн хуулиа эрхэмлэн дээдлэх, хууль, эрх зүй, сахилга, ёс зүй, цэргийн дүрмүүдийн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор үндсэн хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сахилга ёс зүйн дүрэм, цэргийн нийтлэг дүрмүүд,

цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм, танин мэдэхүйн чиглэлээр бэлдсэн асуултын хүрээнд зохион байгуулсан.

Алба хаагчдын өдөр тутмын цэргийн албаны харилцааг хэвшүүлэх, цэргийн дүрэмт хувцсыг зөв өмсөж хэрэглүүлэх, иргэд, үйлчлүүлэгчтэй зөв харьцах, эерэг хандлагыг нэмэгдүүлэх, сахилга, ёс зүйн зөрчлөөс ангид байлгах, урьдчилан сэргийлэх, зөрчлийг эрт илрүүлж таслан зогсоох зорилгоор сахилга, ёс зүйн салбар хорооны гишүүд газрын хэмжээнд “ЁС ЖУРМЫН ЭРГҮҮЛ”-ээр өдөр бүр ээлжлэн ажиллаж, алба хаагчдад тогтмол хяналт тавин ажилласан байна.

Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн тусгай ажиллагааны офицер, ахмад С.Гомбо “Цэргийн сахилгын дүрэм”-ийн хүрээнд, Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын хүний нөөцийн асуудал эрхэлсэн ахлах мэргэжилтэн Н.Соёлмаа “Төрийн алба хаагчийн ёс зүй” сэдвийн хүрээнд “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын сахилга, ёс зүйн дүрэм”-ээр Тасгийн дарга бөгөөд ахлах шийдвэр гүйцэтгэгч, ахмад Ч.Чулуунбат нар тус тус сургалт зохион байгуулсан.

Мөн Үйлдвэр, аж ахуй барилгын хэлтэс “АХА”, Сургалт-Хүмүүжлийн тусгай байгууллага “АХА”, Баривчлах төв “ЭССЭ”, Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар “ЭССЭ” бичлэгийн тэмцээнүүдийг бие бүрэлдэхүүний дунд зохион байгуулжээ.

Дүгнэлт:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан журам, зааврыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус байгууллага нь иргэн, алба хаагчдын сонгон шалгаруулах, тэдгээрийн мэдлэг боловсрол, ур чадвар, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, тэдний идэвх санаачилга, урам зоригийг өрнүүлэхэд чиглэсэн удирдлага зохион байгуулалтын олон талт арга хэмжээг тодорхой төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, үр дүнг тооцон ажиллаж байна.

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛ**